

ДЭЛХИЙН БАНК ГРУППЫН МОНГОЛ УЛСТАЙ БАЙГУУЛАХ ТҮНШЛЭЛИЙН СТРАТЕГИЙН ХҮРЭЭНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУД

Зөвлөлдөх үйл ажиллагааны зорилго юу вэ?

Зөвлөлдөх үйл ажиллагаа нь Дэлхийн Банк Групп (ДБГ)-ын Монгол Улстай байгуулах Түншлэлийн шинэ стратегийн хүрээ (ТСХ)-нд оролцогч талуудын санал, зөвлөмжийг авах зорилготой.

Түншлэлийн стратегийн хүрээ гэж юу вэ?

Дэлхийн Банк Группын боловсруулж буй Монгол Улстай байгуулах Түншлэлийн шинэ стратегийн хүрээ нь 2021-2025 онуудад ДБГ-ын Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагаа, дэмжлэг туслалцааны тэргүүлэх салбарын чиглэлийг тодорхойлох юм. Тус Түншлэлийн стратегийн хүрээ нь зөвлөлдөх үйл ажиллагааны үеэр оролцогч талуудаас авсан саналаас гадна, дараах баримт бичиг, судалгаанд тулгуурласан байна:

- Монгол Улсын хөгжлийн стратеги, зорилтууд
- Монгол Улс ядуурлыг бууруулах, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих тэргүүлэх чиглэлүүдийг системтэйгээр нотолгоонд суурилсан байдлаар тодорхойлсон судалгаа болох [Монгол Улсын Нийгэм эдийн засгийн хөгжлийн цогц дүн шинжилгээ/оношилгоо](#)ны гол дүгнэлтүүд
- Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн загварын тойм судалгаа (2020 оны 9-р сард нийтлэгдсэн) болон ДБГ-ээс хийсэн бусад судалгаа
- ДБГ-ын харьцангуй давуу талууд (Монголд үйл ажиллагаа явуулж буй хөгжлийн бусад түнш байгууллагуудтай харьцуулахад)

Хэлэлцүүлэх гол асуултууд:

1. Дараагийн таван жилд Монгол Улсад баримтлах Дэлхийн Банкны стратегийн гол зорилго нь юу байх ёстой гэж та бодож байна вэ?
2. Дэлхийн Банкны тодорхойлсон дэмжлэг туслалцаа үзүүлэх чиглэлүүдийг зөв зүйтэй, тохиромжтой гэж та үзэж байна уу? Өөр ямар нэг чухал чиглэлийг орхигдуулсан байна уу?
3. Дэлхийн Банкнаас Монгол Улсад үзүүлэх дэмжлэгийг хэрэгжүүлэхэд саад учруулж болзошгүй ямар гол эрсдэл байна вэ? Мөн хэрэгжилтийг хурдасгах ямар боломжууд байна вэ?

Хэнтэй зөвлөлдөх вэ?

Зөвлөлдөх үйл ажиллагаанд төр засгийн газар (төв болон орон нутгийн засаг захиргаа), хөгжлийн түнш, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид оролцохоос гадна бусад талууд мөн оролцох боломжтой.

Оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх вэ?

ДЭЛХИЙН БАНК ГРУППЫН МОНГОЛ УЛСТАЙ БАЙГУУЛАХ ТҮНШЛЭЛИЙН СТРАТЕГИЙН ХҮРЭЭНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Зөвлөлдөх үйл явцыг цахим уулзалт (КОВИД-19 цар тахлаас үүдэн) болон онлайн/цахим платформ ашиглан явуулснаар оролцогч талуудыг өргөн цар хүрээтэй оролцох боломжоор хангах юм. Зөвлөлдөх цахим уулзалтыг нэгдсэн хуралдаан, хэлэлцүүлгийн хэлбэрээр хөндлөнгийн чиглүүлэгчтэйгээр зохион байгуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд бүлгийн хэлэлцүүлэг хийх юм. Уулзалтууд синхрон орчуулгатай явагдана. **Онлайн хэлэлцүүлгийн** хувьд онлайн платформ нь сонирхсон оролцогч талуудад Дэлхийн Банкны хэлэлцүүлгийн вебсайтаар дамжуулан өөрсдийн санал сэтгэгдлээ илгээх боломжийг олгоно.

Өмнө нь ямар хэлэлцүүлгийг зохион байгуулсан бэ?

Энэ удаагийн зөвлөлдөх үйл ажиллагаа нь 2017-с 2019 онд зохион байгуулсан өмнөх хоёр шатны зөвлөлдөх уулзалтууд дээр тулгуурлаж байна.

2017 оны 8-с 10 дугаар сард зохион байгуулагдсан эхний шатны зөвлөлдөх уулзалтууд болон онлайн санал асуулгын үеэр Улаанбаатар хот болон 4 бүсэд Засгийн газар, Улсын Их Хурал, хөгжлийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшлийн салбар болон орон нутгийн оролцогч талуудын 400 гаруй оролцогчид оролцож, [Монгол Улсын Нийгэм эдийн засгийн хөгжлийн цогц дүн шинжилгээ/оношилгоо](#)ны баримт бичиг болон шинэ ТСХ-ний талаар санал бодлоо хуваалцсан юм.

Дараагийн шатны хэлэлцүүлгийг 2018 оны 12-р сараас 2019 оны 2-р сар хүртэл зохион байгуулж, ТСХ-ний төсөлд оролцогч талуудын саналыг тусгасан билээ. Эхний хоёр шатны зөвлөлдөх үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [энэхүү холбоосоор](#) үзэх боломжтой.

Одоо зохион байгуулж буй гурав дахь буюу эцсийн шатны хэлэлцүүлэгт Дэлхийн Банк Группээс Монгол Улсад үзүүлэх дэмжлэг түслалцааны чиглэлүүдийн талаар олон талын оролцогч талуудаас санал авч, тэдгээр саналыг ТСХ-ний эцсийн төсөлд тусгах зорилготой.

Оролцогчдоос ирүүлсэн саналыг ТСХ-д хэрхэн тусгах вэ?

Зөвлөлдөх уулзалтын үеэр өгсөн санал, сэтгэгдэл, зөвлөмжийн хураангуйг ТСХ-ний эцсийн хувилбарт тусгана. Мөн уулзалт болон онлайн хэлэлцүүлэгийн талаарх тоймыг тухайн санал сэтгэгдэл, зөвлөмжийг ирүүлсэн хувь хүн эсвэл албан байгууллагын мэдээллийг дурдалгүйгээр Дэлхийн Банкны Монгол Улс дахь вебсайтад олон нийтэд нээлттэй байршуулна.

ТСХ-г хэн үзэх боломжтой вэ?

ТСХ-г Дэлхийн Банк Группын Гүйцэтгэх Захирлуудын зөвлөл хэлэлцсэний дараа олон нийтэд нээлттэй болгож Дэлхийн Банкны Монгол Улс дахь вебсайтад байршуулна.

ДБГ-ын Монгол Улс дахь үйл ажиллагааны одоогийн стратегийн гол чиглэл юу вэ? Ямар төсөл, хөтөлбөрийн багц хэрэгжүүлж байгаа вэ?

Дэлхийн Банк Группын Монгол Улстай байгуулсан 2013-2017 оны [Түншлэлийн стратегийн](#) дагуу тус банк үндсэн гурван чиглэлээр Монгол Улсад дэмжлэг үзүүлж байна. Үүнд:

ДЭЛХИЙН БАНК ГРУППЫН МОНГОЛ УЛСТАЙ БАЙГУУЛАХ ТҮНШЛЭЛИЙН СТРАТЕГИЙН ХҮРЭЭНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

- Уул уурхайн эдийн засгийг тогтвортой, ил тод удирдахад Монгол улсын чадавхийг бэхжүүлэх.
- Хот болон хөдөөд эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжих тогтвортой, олон тулгуурт суурь бий болгох.
- Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг илүү сайн хүргэх, нийгмийн хамгааллын системийг сайжруулах, гамшгийн эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох замаар эмзэг байдал, өсөн нэмэгдэж буй тэгш бус байдлын асуудлыг шийдвэрлэх.

Тус стратегийг 2020 оны 12-р сарын 31-ний өдрийг дуустал сунгасан.

2020 оны 10-р сарын байдлаар Дэлхийн Банкнаас Монгол Улсад олгож буй нийт зээл/буцалтгүй тусламжийн багц 349.51 сая ам. доллар байгаа бол ОУСК-ийн өөрийн хөрөнгө оруулалтын багц нь өөрийн хөрөнгөөс 526 сая ам.доллар, бусад байгууллагуудаас 840 сая ам.доллар төвлөрүүлжээ. Олон Талт Хөрөнгө Оруулалтын Баталгааны Агентлаг (ОТХОБА)-аас Монголд гаргасан баталгаа буюу ОТ уурхайн төслийг хөгжүүлэхэд гаргасан баталгаа нь Зүүн Ази, номхон далайн бүс нутагтаа хамгийн том нь буюу 858 сая ам.доллар (СЖ20-ийн байдлаар) байна.

Дэлхийн Банк нь зээл болон буцалтгүй тусламжаас гадна Монгол Улсын дунд болон урт хугацааны хөгжлийн зорилтыг дэмжих, стратегийн гол чиглэлээр засгийн газраас явуулах шинэчлэлийг дэмжихээр чадавхийг бэхжүүлэх хүрээнд аналитик болон зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. ОУСК нь худалдаа, экспортыг хөнгөвчлөх, хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгө оруулалтыг дэмжих, уул уурхай дахь усны менежмент, төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрхзүйн орчны шинэчлэл, өртгийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх зэрэг чиглэлээр (2020 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар) нийтдээ 5.1 сая ам.долларын төсөв бүхий зөвлөгөө өгөх төслүүдийг хэрэгжүүлж байна.

Дэлхийн Банк Группын Монгол Улсад хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг эдгээр цахим хуудсаас авах боломжтой: www.worldbank.org/mongolia; www.ifc.org; www.miga.org.

ДЭЛХИЙН БАНК ГРУППЫН ТҮНШЛЭЛИЙН СТРАТЕГИЙН ХҮРЭЭНИЙ ТӨСӨЛ

ДБГ-ын ТСХ-ний одоогийн төсөл нь дараах үндсэн гурван тулгуурт төвлөрч байна: (i) Эдийн засгийн сэргэлт, тогтвортой байдлыг дэмжих; (ii) Өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, чанартай ажлын байр бий болгох, (iii) Хүмүүн капиталыг өргөжүүлэх ба амьдралын чанарыг сайжруулах. Эдгээр тэргүүлэх чиглэлүүд бүхий тулгуурууд нь Засгийн газрын хэрэгцээ шаардлага, Цогц дүн шинжилгээ/оношилгооны гол дүгнэлтүүд, Монголд явуулсан өмнөх хоёр шатны хэлэлцүүлэг болон ДБГ-ын харьцангуй давуу тал дээр үндэслэн боловсруулагдсанаас гадна өмнөх ТС-д (2013-2017 оны) суурилж байна. Мөн ДБГ-ээс одоо хэрэгжүүлж буй зээл, буцалтгүй тусламжийн багц болон зөвлөх үйлчилгээ нь ТСХ-ний үр дүнгийн хүрээний томоохон хэсгийн суурь болж байгаа тул тэдгээрийг бодолцсон байна. Дэлгэрэнгүйг ТСХ-ний төслөөс харна уу.

ДЭЛХИЙН БАНК ГРУППЫН МОНГОЛ УЛСТАЙ БАЙГУУЛАХ
ТҮНШЛЭЛИЙН СТРАТЕГИЙН ХҮРЭЭНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ТСХ-ний чиглэл ба зорилтууд

Ерөнхий зорилго: уян хатан сэргэлт, хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг дэмжих

<p>Чиглэл 1:</p> <p>Эдийн засгийн сэргэлт, тогтвортой байдлыг дэмжих</p> <p>- ТХЗ 8: Зохистой хөдөлмөр, эдийн засгийн өсөлт</p> <p>- ТХЗ 10: Тэгш бус байдлыг бүүрүүлэх</p>	<p>Чиглэл 2:</p> <p>Өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, чанартай ажлын байр бий болгох</p> <p>ТХЗ 1: Ядууралгүй байх - ТХЗ 4: Чанартай боловсрол - ТХЗ 5: Жендэрийн тэгш байдал - ТХЗ 7: Боломжийн ба цэвэр эрчим хүч - ТХЗ 8: Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлт - ТХЗ 9: Аж үйлдвэр, инноваци ба дэд бүтэц - ТХЗ 10: Тэгш бус</p>	<p>Чиглэл 3:</p> <p>Хүмүүн капиталыг өргөжүүлэх ба амьдралын чанарыг сайжруулах</p> <p>ТХЗ 1: Ядууралгүй байх - ТХЗ 2: Тэг өлсгөлөн - ТХЗ 3: Эрүүл мэнд, сайн сайхан байдал - ТХЗ 4: Чанартай боловсрол - ТХЗ 5: Жендэрийн тэгш байдал - ТХЗ 8: Зохистой хөдөлмөр, эдийн засгийн өсөлт - ТХЗ 9: Аж</p>
<p>1.1 КОВИД-19 цар тахлын нөлөөллийг арилгахын тулд эдийн засгийн яаралтай тусламж үзүүлэх</p> <p>1.2 Макро- төсвийн удирдлага, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх</p>	<p>2.1 Бизнесийн орчныг сайжруулах</p> <p>2.2 Тогтвортой уул уурхай, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих</p> <p>2.3 Уул уурхайн бус салбар дахь бүтээмж, хотын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх</p>	<p>3.1 Эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээний хүртээмжийг сайжруулах (үүнд КОВИД-19 цар тахлын эрүүл мэндийн хариу арга хэмжээг багтаасан)</p> <p>3.2 Нийгмийн хамгааллын тогтолцооны үр ашиг, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх</p> <p>3.3 Амьжиргааг сайжруулах, хүрээлэн буй орчин, уур амьсгалыг хамгаалах</p>

Холбогдох бусад сэдэв:

Засаглал: төрийн байгууллагуудыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээ үзүүлэх чанарыг сайжруулах

Уян хатан байдал: эдийн засаг, хүн ба хүрээлэн буй орчны уян хатан чанарыг дээшлүүлж, сайн сайхан байдлыг бий